

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2023/40/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2023 он	Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Аудитор С.Санчирмаа Утас: 99282488 Цахим хаяг: sanchirmaas@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13, Факс: (976) 70-48-34-12
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН УЛАМЖЛАЛТ
АНАГААХ УХААНЫ НЭГДСЭН
ЭМНЭЛГИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Б.СЭРГЭЛЭН ТАНАА

2023.02.24 № 34
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говь-Алтай аймгийн Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр баталсан. Энэ хуулиар байгууллагын үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулсан байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь тайлант онд 7 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 28 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

0702000068

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

(мянган төгрөг)

	Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	44,356.60	73,812.94
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	477,114.21	456,785.66
	Нийт хөрөнгийн дүн	521,470.81	530,598.60
	Нийт өр төлбөрийн дүн	54,958.55	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	466,512.26	530,598.60
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	521,470.81	530,598.60
Үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	721,519.98	771,357.05
	Үйл ажиллагааны зардлын дүн	546,235.84	705,162.31
	Үйл ажиллагааны үр дүн	175,284.14	66,194.73
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	2,108.39
	Үйл ажиллагааны нийт үр дүн	175,284.14	64,086.34
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	291,228.12	466,512.26
	Тайлант оны үр дүн	175,284.14	64,086.34
	Эцсийн үлдэгдэл	466,512.26	530,598.60
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	462,993.10	759,173.14
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	454,897.10	714,517.26
	Үйл ажиллагааны ЦМГ	8,096.00	44,655.88
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(8,096.00)	(16,298.00)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	0	0
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	0.00	28,357.88
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	28,357.88
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	776,400.00	730,815.26
	Урсгал зардал	776,400.00	730,815.26
	Хөрөнгийн зардал	0	0
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	776,400.00	759,173.14
	Эрүүл мэндийн даатгалын сангаас	744,400.00	724,798.45
	Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл	-	28,357.88

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 2.5 сая төгрөгийн алдаа¹, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг зөрчсөн 2.5 сая төгрөгийн гүйлгээг аудитын явцад гүйлгээг нөхөн шивүүлж, зөрчлийг арилгасан.

Үүнд:

- ✓ **Хууль тогтоомжтой холбоотой:** Бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөрийн дүн татварын нэвтрэлтийн нэгдсэн системд бүртгээгүй 2.5 сая төгрөгийн гүйлгээг системд нөхөн шивүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн

¹ Тайлагнасан санхүүгийн тайлангийн үзүүлэлт, тайлагнасан байвал зохих үзүүлэлтийн хоорондын зөрүү. Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт 0.7 сая төгрөгийн зөрчил² илэрснээс зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 0.7 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн.

3.1 Албан шаардлага

- ✓ Нэгдсэн халаалтын системд холбогдсон боловч тоолуур тавиулаагүй нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2-т "нэгдсэн халаалтын системд холбогдсон барилга байгууламжийг хэмнэлтийн горимд тохируулах, тоолуур ашиглах;" заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Татварын тайланд хувь хүний орлогын албан татварын дүнг 244.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Хөдөлмөрийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1-т "Ажил олгогч ажилтны ажлын байрыг хэвээр хадгалах тохиолдолд ажлыг нь түр, хөдөлмөр эрхлэлтийн харилцаа дуусгавар болсон тохиолдолд бүрмөсөн хүлээн авна", 110 дугаар зүйлийн 110.3-т "Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа нь дуусгавар болж байгаа ажилтанд ажилласан хугацаанд ногдох ээлжийн амралтын тооцоо хийж, цалинг олгоно", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/191 дүгээр тушаалын хавсралтын 2 дугаар зүйлийн 2.8-т "Ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцлах, дуусгавар болгох үед ажил олгогч нь ажилтантай ээлжийн амралтын тооцоог дараах байдлаар хийнэ" заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Тээвэр шатахууны зардлыг 340.4 мянган төгрөгөөр, бичиг хэргийн зардлыг 82.2 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-т сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх; 15.2.4-т "бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх зэргээр бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зардлыг хэмнэх" заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой асуудал

Илрүүлэлт: Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолын 6 дугаар зүйл "Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн автомашинд тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар олгох арга хэмжээг 2022 онд багтаан зохион байгуулах, Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолын 1-т "Автомашин хэрэглээг хуулиар хязгаарласантай холбогдуулан суудлын автомашин ашиглах эрх бүхий албан тушаалтнаас бусад албан тушаалтны албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа, төрийн өмчид бүртгэлтэй автомашины талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт, орон нутгийн өмчид бүртгэлтэй автомашины талаарх мэдээллийг аймаг, нийслэлийн Засаг даргад тус тус

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хүргүүлж, тогтоосон хугацаанд батлагдсан хуваарийн дагуу заасан байршилд татан төвлөрүүлж, зохих журмын дагуу хүлээлгэн өгөх арга хэмжээ авахыг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, төсвөөс санхүүжилт авдаг бүх байгууллагын дарга нарт тус тус даалгасугай"-ийн дагуу автомашиныг парклаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Байгууллагын эзэмшиж ашиглаж байгаа авто тээврийн хэрэгслийг тод өнгийн дэвсгэр бүхий улсын дугаартай болгох, автомашиныг парклуулах ажлыг зохион байгуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 12 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/							
	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
УАУНЭ	2	166.0	-	-	1	166.0	1	-
Нийт дүн	2	166.0	-	-	1	166.0	1	

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	-	1	-	-	1	-	-	-
	НИЙТ		1			1			